

**ЗАРЛИГААР ЗАРСАН УЛИАСТАЙ ХОВДЫН ХЭРГИЙГ БҮГД ЗАХИРАН
ШИЙТГЭГЧ САЙД ЧИН АЧИТ БЭЙС ГОНЧИГДАМБЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ЗАРИМ АСУУДАЛ**

Н.Алтантөгс

Монгол төрийн түүхийн музей. harizmatika@yahoo.com

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд МУУТА-т хадгалагдаж буй архивын зарим баримтад үндэслэн баруун хязгаарын сайд Гончигдамбын үйл ажиллагааны тухай өгүүлэв.

Түлхүүр үг: Зарлигаар зарсан Улиастай Ховдын хэргийг бүгд захиран шийтгэгч сайд, чин ачит бэйс Гончигдамба, Ховдын халх жасаа, баруун хязгаар, Богд хаан, Үндэсний хувьсгал

Засагт хан аймгийн хошууны бэйс Гончигдамба 1912 оны II-VI сард Зарлигаар зарсан Улиастай, Ховдын хэргийг бүгд захиран шийтгэгч сайдаар ажилласан байна. Түүнийг баруун хязгаарт сайдаар ажилласан талаар Бурдуков¹, Б.Нямдорж², Ж.Урангуа³ зэрэг судлаачдын дурдатгал, судалгааны зохиолуудад товч дурдаж иржээ. Харин уг сайдын эрх хэмжээ, үйл ажиллагаа, томилогдсон болоод халагдсан үндэслэлийг судлаачид тодорхой авч үзээгүй байна.

Сайд Гончигдамбын үйл ажиллагааны үндсэн чиглэл, авч хэрэгжүүлж байсан арга хэмжээ, Ховдыг чөлөөлж баруун хязгаарын олон хошуудыг тулгар төрд оруулан авахад гүйцэтгэсэн үүргийг тодруулах нь Олноо өргөгдсөн Монгол Улс байгуулагдаж Үндэсний хувьсгал баруун хязгаарт ялсан түүх, монголын төрийн захиргааны өвөрмөц хэлбэр болох төлөөний сайд томилох уламжлалыг судлахад чухал ач холбогдолтой. Тиймээс энэхүү өгүүлэлээр Гончигдамба сайдын томилогдсон болоод халагдсан шалтгаан, тушаалын зорилго, эрх хэмжээ, ажиллах хугацаандаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн зэргийг судалж тодруулахыг зорилоо. Ингэхдээ дараах асуудлуудыг үзэв.

1. Чин ачит бэйс Гончигдамба анх сайдаар томилогдох болсон учир шалтгаан
2. Сайд Гончигдамба баруун хязгаарт сайдаар ажиллах хугацаандаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд
3. Сайд Гончигдамбын үйл ажиллагааны үр дүн, 1912 оны II-IV сарын Ховдын нөхцөл байдал

Чин ачит бэйс Гончигдамба анх сайдаар томилогдох болсон шалтгаан

Чин ван Ханддорж нараас 1911 оны VIII сарын сүүл, IX сарын эхээр⁴ Сайн ноён хан аймгийн Түшээ гүн Ганжууржавын хошууны гүн Магсаржавыг “төв шударга эрс зоригтой бөгөөд улс төрийн хүнд чухал бодлоготойг харгалзан итгэмжилж”⁵ Ховдын халх жасаанд томилон явуулсан бөгөөд тэр үеэс эхлэн Ховдын халх жасаа баруун хязгаарт Үндэсний хувьсгалыг эхлүүлэх нууц штабын хэлбэрээр ажиллаж эхэлсэн бололтой. Ингээд баруун хязгаарын хэрэг явдал тодорхой хариуцсан төрийн сайдын зиндааны албан тушаалтангүй, харин орон нутгийн захиргаа болон халх жасааны захирагч Магсаржавын эрх мэдлийн хүрээнд өрнөж иржээ. Тухайлбал, Нийслэл хүрээний зааврын дагуу Цэцэрлэгийн чуулганы даргын тамгыг хамаарсан засаг улсад туслагч гүнгээс 1912.I.5-нд туслагч жанжны хэвэй нар сангийн хэргийг байцаан захирах засгийн түшмэлийг бүрнээ татан хасваас зохихыг Ховдын халх жасааны хэрэг

¹ Бурдуков, А. В. *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987

² Нямдорж, Б. *Ховдын хязгаар 1911-1919 он*, УБ, 2006

³ Урангуа, Хэрээд Ж. *XX зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919)*, УБ, 2006

⁴ Архивын баримтын цаг хугацааг билгийн тооллоос аргын тоололд шилжүүлэхдээ Бямбажаргал, Л, Цовоохүү, Ч. *Билиг аргын тоолол /XV, XVI, XVII жаран, 1867-2046/*, УБ, 2002 номыг баримтлав

⁵ Чойбалсан, Х, *Ардын Хатанбаатар Магсаржав*, УБ, 1942, 16-17-р тал

шийтгэгч гүн Магсаржав, туслагч Мэйрэн нарт тушааснаас⁶ үзэхэд хувьсгалд бэлтгэхэд орон нутгийн оролцоо их байсан нь харагдана.

Тусгаар тогтнолын үйл хэргийг зоригтой ухуулж байсан⁷ Магсаржаваас төв засгийн газарт 1912 оны II сарын эхээр Ховдын манж сайд түшмэд цэрэг элсүүлэн монголчуудыг эсэргүүцэн байлдахаар завдан буй тухай мэдээ иржээ. Засгийн газраас энэ асуудлыг хянаж үзээд нэгд, Ховд бол Монгол Улсын хязгаар газар мөн, хоёрт, манж сайд цэрэг элсүүлж газар орныг эзлэхийг санаархаж буй тул Ховдод суугаа манж хятад түшмэдийг даруй хөөн буцаах шаардлагатай хэмээн дүгнэсэн байна⁸. Ингээд ийм чиг үүрэгтэй сайд томилохоор Дотоод яамнаас 1912.II.9-нд Богд хаанд айлтгаж сайд томилох бол хэнийг томилохыг заахыг гуйжээ⁹.

Сайд нарын ийнхүү шийдвэрлэж айлтгасан явдал бол монгол төрийн эртний уламжлалыг харгалзсан хэрэг байж болохоор байна. Хязгаар нутагт төлөөний сайд томилон ажиллуулах уламжлал бол манж нарын төрт ёсны уламжлал төдий биш бололтой. Эрт цагаас нүүдэлчдийн эзэн хаанаас тодорхой хязгаар нутагт төлөөний сайд суулгадаг байв. Тухайлбал, Хүннүгийн шаньюй эзэлж авсан хязгаар нутагтаа жичжу ван томилдог байсан¹⁰ билээ.

Баруун хязгаарын сайдын тушаалд 1912.II.10-ны Богд хааны зарлигаар Шүүх яамны дэд сайд, Засагт хан аймгийн засаг хошууны бэйс Гончигдамбыг сайдаар томилов¹¹. Ингэхдээ хэд хэдэн зүйлийг заасан байна. Нэгд, уг тушаалын нэрийг Зарлигаар зарсан Улиастай Ховдын хэргийг бүгд захиран шийтгэгч сайд хэмээжээ. Үүнд, Зарлигаар зарсан гэдэг нь хааны тодорхой нэг зарлигийг, тухайлбал “зах этгээдийг сэргийлэн газар орныг бэх бат болгох” зарлигийг биелүүлэх зорилгоор томилсныг, Улиастай, Ховдын хэргийг бүгд захиран шийтгэгч гэдэг нь түүний эрх хэмжээ Сайн ноён хан, Засагт хан хоёр аймаг, Ховдын манж амбаны захиргаанд байсан баруун хязгаарын олон хошуудыг хамаарахыг заажээ. Хоёрт, Улиастай, Ховдын харъяат газрыг сайнаар тохинуулан нам гүм болгохыг тушаажээ. Үүнд, Ховдын манж сайдыг хөөн явуулах, тухайн үед хараахан Богд хаанд албан ёсоор дагаар ороогүй байсан баруун хязгаарын олон хошуудыг оруулан авах явдал багтана. Гуравт, хязгаарын хэргийг нам гүм болгож гурван сарын хугацаанд хойш буцаж ирэгтүн гэжээ. Энэ нь хааны зарлигийг 1912.V.10-наас өмнө бүрэн биелүүлсэн байхыг хэлжээ. Дөрөвт, ийнхүү сайд томилсон явдлыг Засгийн газрын бүх яамд болон уул сайдад хамаарах болсон Засагт хан, Сайн ноён хан аймгийн чуулганы дарга, жанжин нарт тушааж, Зарлигаар зарсан сайдын бие хүрч тушаах дайчлах бүрт хичээнгүйлэн дагаж явуулсугай гэжээ. Баруун хязгаарын олон хошууд хараахан дагаар ороогүй байсан тул тэдгээр хошуудад Засгийн газраас тушаан илгээх бичиг илгээх эрх үүсээгүй байв. Иймээс сайд томилсон явдлыг зөвхөн баруун хоёр аймагт зарласан байна.

Богд хаанаас Гончигдамбыг сайдад сонгосон шалтгаан нь, нэгд, түүний нутаг хошуу Ховдод ойр, хоёрт, Жалханз хутагтай дотно харилцаатай байсан бөгөөд Жалханз хутагтыг баруун хязгаарт очиж ажиллахад илүү дөхөм байв. Учир нь Богд хаан үүний урд 1912.I.9-нд Жалханз хутагт Дамдинбазарын баруун хойд хязгаарт “чухал хэргийг гүйцэтгүүлэхээр” явуулсан байлаа¹².

Гончигдамбын томилогдохоос өмнө эрхэлж байсан ажил албаны тухайд тэрээр Богд хааны зарлигаар 1912.I.25-нд Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайдад томилогдсон байсан бөгөөд Богд хааны зарлигаар түүнийг баруун хязгаарт сайдаар томилох үед

⁶ МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 6-р нугалбар

⁷ Бурдуков, А. В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 57-р тал

⁸ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-291, 8-р нугалбар

⁹ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-291, 8-р нугалбар

¹⁰ Болдбаатар, Ж, *Лүндээжанцан, Д, Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал*, УБ, 1997, 17-р тал

¹¹ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-291, 8-р нугалбар

¹² Очирбат, Г, *Жалханз хутагт Дамдинбазар бол 1911 оны Монголын Үндэсний хувьсгалын удирдагчдын нэг мөн*, Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал, УБ, 2002

Шүүх яамнаа тушаалдаа ороод 16 хонож байв¹³. Богдын зарлиг гарах үед тэрээр үүнийг хараахан дуулаагүй, харин ч баруун хязгаар нутаг орон түгшүүртэй байгаа тухайд өөрийн хошууны төлөө ихэд санаа зовнисон учир 1912.ІІ.13-нд сайдын тушаалаас гурван сарын чөлөө гуйж байжээ. Түүнийг шүүх яамны дэд сайдаас өөрчилж зарлигаар баруун хязгаарт сайдаар нэгэнт томилсон тул Богд хаанаас түүнд чөлөө өгөөд байх шаардлага нэгэнт үгүй болсон байв¹⁴.

Ийнхүү сайд Гончигдамба Монгол Улсын харъяат газар болох баруун хязгаарыг сэргийлэн газар орныг бэх бат болгох, тодруулбал Ховдын манж сайдыг хөөн явуулах, баруун хязгаарын олон хошуудыг Монгол Улсад дагаар оруулах, хувьдаа өөрийн хошуу нутгийг манж сайдын түрэмгийллээс авран хамгаалах зорилго өвөртлөн Нийслэл хүрээнээс Улиастайг чиглэн морджээ.

Аливаа сайд томилоход түүний албан тушаалын бүтэн нэрийг бичсэн тамга заавал цутган олгох ёстой боловч ямар нэг шалтгаанаар Гончигдамбад сайдын тамгыг үйлдэж олгоогүй аж. 1912.ІІІ.28-нд илгээсэн бичигтээ тэрээр “сайдын тамгыг цутгаж ирээгүй тул уг тушаасныг дагаж засгийн тамгыг дарж” байгаагаа тайлбарласан байдаг. Тэрээр халагдах хүртлээ мөнөөх хошуу ноёныхоо тамгаар албан бичгээ тамгалсаар байсан ба тамгагүй байсан нь түүний үйл ажиллагаанд тодорхой бэрхшээл үүсгэж байсан байж болох юм.

Түүнийг томилогдон очих үед Ховдын нөхцөл байдалд зарим өөрчлөлт гараад байв. Ховдын халх жасааны шийдвэртэй үйл ажиллагаа нь манж амбаны хажуу бөөрөнд томоохон заналхийлэл болж байсан тул жасааны захирагч Магсаржавыг устгахаар шийджээ. Манж сайд өөрийг нь устгахаар зэхэж буйг олж мэдсэн Магсаржав амь биеийг хамгаалахын учир, жасааны модон тамгыг хадгаар боож өвөртлөн, их цэрэг дагалдуулан ирж хятад манж сайд түшмэдэд тавьсан зүрхний өшөө хорслыг хэзээ ч умартахгүйгээр хүйс тэмтэрч хариугаа авахаа хэлээд яаравчлан морджээ¹⁵. Ингэснээр жасаа захирагчгүй үлдэв. Иймээс Засагт хан аймгийн хамаарсан чуулганы дарга бэйсийн зэрэг үйзэн түшээ гүнгээс цагийн байдлыг хянаж үзээд 1912.ІІІ.17-нд дэд зэрэг тайж Баатарыг Ховдын халх жасааны захирагчаар томилон суулгасан байна¹⁶. Яг энэ үетэй давхцан Улиастайд төрийн сайд Гончигдамба хүрэлцэн ирж, Ховдын халх жасааг шуурхай удирдлагаар хангах боломжтой болов.

Сайд Гончигдамбын авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ

Сайдаас 1912.ІІІ.28-нд дөрвөдийн зүүн гарын чуулганы дарга туслагч жанжин Төгс хүлэг далай хан, дэд Чуулганы дарга засаг төрийн Жүн ван, баруун гарын Чуулганы дарга Туслагч жанжин засгийн хошой Чин ван нарт бичиг явуулсан байна¹⁷. Энэ бичигт баруун хязгаарын хошуудад хандан хэд хэдэн асуудал уриалав. Нэгд, монголчууд Улиастай Хүрээний зэрэг газар суусан манж улсын сайд түшмэд цэргийг үлдэн буцааж, газар орныг ариун болгож, монголчуудын хааныг эрдэнийн сууринд залж тулгар төр байгуулж тусгай улс болсныг албан ёсоор зарлан мэдэгдэж, гагцхүү дөрвөд өөлдийн харъяат Ховд хотноо Чин улсын сайд түшмэл цэрэг суусаар буйг онцлон тэмдэглэсэн байна. Хоёрт, харъяат газар орны монгол овгийн хан, ван, гүн, засгууд дэмий зүүнийг харж, барууныг хараалан одоо болтол манж сайдыг Ховдод агуулан суулгасан нь үнэхээрийн хол бодлогогүй болохыг шүүмжилжээ. Гуравт, дөрвөдийн зүүн гарын чуулганы дарга туслагч жанжин Төгс хүлэг далай хан, дэд Чуулганы дарга засаг төрийн Жүн ван, баруун гарын Чуулганы дарга Туслагч жанжин засгийн хошой Чин ван нар зах залгаагийн монгол овгийн өөлд мянгад, захчин нартай хурдлан зөвлөж нийт хүч нэг сэтгэлээр цагийг өрсөж бодлогыг тогтоож харъяат хотын Чин улсын сайд түшмэл цэргийг бүрнээ үлдэн буцаахыг уриалжээ. Дөрөвт, манж сайдыг хөөн явуулсны дараа хүүгийн зүйлийг тооны ёсоор

¹³ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-291, 2-р нугалбар

¹⁴ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-291, 40-р нугалбар

¹⁵ Чойбалсан, Х, Ардын Хатанбаатар Магсаржав, УБ, 1942 он, 24-25-р тал

¹⁶ МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 4-р нугалбар

¹⁷ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-364, 12-р нугалбар

гардан хүлээн авч, сайн чадах гүн засагт хадгалуулан сэргийлүүлэе хэмээжээ. Тавд, хотын иргэдэд амар тайван байхыг зарлаж, хулгайлах булаах зэрэг хэрэг дэгдээхгүй нам тайван байлгахыг заажээ. Зургаад, энэ хэргийг алгуурлан удаж хэрхэвч болохгүй хэмээжээ.

Ийнхүү сайд Гончигдамба нэн тэргүүнд дөрвөд аймгийн ноёдыг дагуулан авахыг эрмэлзсэн байна. Ховдын хязгаарыг нутгийн ноёд, олон түмний хүчээр чөлөөлөхөөс бус зэргэлдээ баруун хоёр аймгийн ноёд, ард түмний хүчээр бүтээх ажил биш байлаа.

Энэ үүднээс тэрээр хэсэг хугацааны дараа баядын Түмэн гүнийг урьж Ховдын хязгаарыг Халхад нэгтгэх тухай хэлэлцээр хийж амжилтанд хүрчээ. Тэгээд Түмэн гүн дөрвөдийн зүүн гарын дэд дарга байсан баядын ноён Түгээмэл вантай уулзахаар явжээ¹⁸. Удалгүй 1912.IV.29-нд Дөрвөдийн зүүн гарын дэд чуулганы дарга засаг төрийн жүн ван Түгээмэл тэргүүтэй хэсэг ноёд Богдод дагаар орох бичиг өргөн Монгол Улсад албан ёсоор дагаар оржээ¹⁹. Энэ бол сайд Гончигдамбын томоохон амжилт байсан юм.

Баруун хязгаарт ажиллахад Ховдын халх жасаа Гончигдамбын гол нүд, чих болж байжээ. Тиймээс ч тэрээр уг жасааны хүн хүчийг нэмэгдүүлж Магсаржавыг явснаас хойш сулраад байсан үйл ажиллагааг нь идэвхжүүлж байр суурийг нь бэхжүүлэхийг зорьж байжээ.

Халхын жасааны захирагч тайж Баатарт 1912.IV.7-нд бичиг тушаав²⁰. Тэрээр тайж Баатарыг Тагна Урианхайн ард нар бүлэглэн хоршоолж хятад худалдаачдыг дээрэмдсээр буйг анхааруулаад, түшмэл хүн үүнийг найрамдуулан илбэн тохинуулж эвлэрүүлэхийг зааж, мөн баруун хязгаарын байдлыг лавлан сурвалжилж хэрэв чухал мэдээ байваас даруй мэдэгдэхийг даалгасан байна.

Ховдын халх жасаанд даалгасан үүргийг биелүүлэхэд хүн хүч дутмаг байгааг харгалзан сайд Гончигдамба Засагт хан аймгийн хамаарсан чуулганы даргад тушааж, ухвартай сайн түшмэл нэгийг нэмэн томилж Халхын жасаанд 1912.IV.16-ны дотор жасаалан суулгахыг даалгав²¹. Засагт хан аймгаас хошууны занги Аюушийг томилсон боловч түүний бие өвдөж саатсан учир хугацаа алдаж, сайдын тушаасан хугацаа өнгөрсөн хойно 1912.IV.22-нд хошууны захирагч Түвдэнийг томилсон байна²². Түвдэн Баатарын хамт жасаа татан буугдтал тууштай зүтгэжээ.

Ховдын жасааны захирагч Баатар өвчний улмаас чөлөө гуйсанд 1912.V.20-нд жасааны чухал хэргийг саатуулж болохгүй тул 1912.V.25-ныг хүртэл ажиллах, тэр хугацаанд Засагт хан аймгаас орны түшмэлийг томилохоор шийдвэрлэсэн байна²³.

Гончигдамбын эрх үүрэгт зөвхөн Ховд төдийгүй өөрийн суугаа Улиастайн газар хамаарах тул тэрээр Улиастайн хэрэг явдалд бас анхаарлаа хандуулж байжээ. Тухайлбал, Улиастайд сууж байсан хуучин манж сайдын эх адаггүй хятад манж үсгийн бичиг судруудыг Нийслэл хүрээнээс сайн чадах түшмэд томилуулан авч цэгцлэн шийтгэхийг зорьж, түшмэд гуйн Дотоод яаманд 1912.V.20-нд өргөх бичиг илгээж байв²⁴. Дотоод яамнаас 1912.VI.6-нд хариу ирүүлж, уг хэргийг дараа тушаахыг хүлээх, тэр хүртэл бэх бат авдар байшинд агуулж сайтар хадгалахыг тушаасан байдаг²⁵.

Сайд Гончигдамба бас баруун хоёр аймгаас цэрэг дайчлахаар оролдож байжээ. Засагт хан аймгийн жанжин нараас тушаасан ёсоор түшмэл цэрэг нарыг томилж сэргийлүүлэн суулгаж

¹⁸ Бурдуков, А. В. *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 63-р тал

¹⁹ МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 6-р нугалбар

²⁰ МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 2-р нугалбар

²¹ МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 1-р нугалбар

²² МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 3-р нугалбар

²³ МУУТА, Ф-А144, Д-1, ХН-3, 5-р нугалбар

²⁴ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-364, 6-р нугалбар

²⁵ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-364, 5-р нугалбар

бэлтгэсэн бол Сайн ноён хан аймаг цэрэг дайчилгаанд тун удаашралтай, хойрго хандаж байв. Түүнээс гадна Засагт хан аймгийн цэргүүд “замын зуур хэрэг дэгдээх ба, сахих газарт элдвээр муу явж” байжээ²⁶. Өөрөөр хэлбэл төрийн сайдын хувьд мэдээж хууль бус үйлдэл болох хятад худалдаачдыг дээрэмдэх, өрийн дансыг шатаах хэрэгт цэргүүд нутгийн ардуудтай хамжин оролцож байсан бололтой.

Ийнхүү тэрээр Ховдын манж сайдад шахалт үзүүлж хөөн явуулах, баруун хязгаарын хошуудыг оруулан авах, Ховдын халх жасааг бэхжүүлэх, цэрэг дайчлах зэрэг чиглэлээр хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Сайд Гончигдамбын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнгээ өгч, баруун хязгаарын ноёдыг хөдөлгөөнд оруулав. 1912.V сард Дөрвөдийн баруун зүүн гарын чуулганы дарга, жанжин нар сайдын тушаасныг дагаж Ховдын жасааны түшмэл нарын хамтаар Ховдын сайд манж нарыг уул нутагт буцаахаар хуудас өгч шаардан үлдэн хөөхийг завдсан байна. Манж сайд шаардлагыг хүлээн авалгүй татгалзаж, бид нар язгуураас тушаалаар ирсэн, Бээжингээс бичиг ирүүлбээс зайлсугай, харин сайн дураар орхин одож үл болно гэсэн хариу өгчээ²⁷.

Сайд Гончигдамба хүрэлцэн ирж, хязгаарын ноёдтой хэлэлцээр хийж, улмаар Дөрвөдийн зүүн гарын Түгээмэл ван тэргүүтэй нөлөө бүхий ноёд Богд хаанд дагаар орж, чин ван Содномжамцой Богд хаанд дагаар орох байр суурь тууштай баримталж, Далай ханы нэр нөлөө унаж эхэлсэн учир 1912 оны V сарын эхэн үес Ховдын манж сайд нар нэгэн удаа буцаах завдсан байна²⁸. Монголчууд зорилгодоо хүрэхэд тун ч ойртсон мэт байв. Гэвч Бээжингээс хийсэн алхам Ховдын нөхцөл байдлыг яах ийхийн зуургүй өөрчлөв.

Алтай шан уулаас Ховдын манж сайдад Ховдыг хэвээр сахихыг шаардаж, удахгүй цэрэг явуулахаар мэдэгдсэнд манж сайд шийдвэрээ буцааж, харин ч Алтайн чанадаас цэрэг авахуулахаар хүн явуулсан аж. 1912 оны V сарын 15-нд Ховдын манж сайд нар хотын гудамжинд зарлал хадав. Зарлалд “Улиастай Ховдын хэргийг ерөнхийлөн захиран шийтгүүлэхээр сайд Наянтыг гаргасан хэмээн Алтай шан уулаас уламжлан Дундад улсын засгийн газраас бичиг ирсэн тул одоо айн цочих зүйлгүй тус бүр хуучин хэвээр суутугай” хэмээжээ²⁹. Мөн ийм агуулгатай бичгийг хятад худалдааны пүүсүүд, нутгийн хошуу ноёдод явуулжээ.

Үүнээс хойш манж сайд эргэж буцалтгүйгээр Ховдыг хамгаалахаар бэлтгэж эхлэв. Алтайн боомт замын цас нэгэнт хайлж, цэрэг хөсөг нэвтрэх боломжтой болсон учир удалгүй хамгаалах цэрэг ирнэ гэдэгт найдаж болохоор болжээ. Иймээс Засгийн газраас сүүлчийн удаа Ховдын манж амбанд анхааруулга өгч тулган шаардахаар элч илгээсэн байна.

V сарын дундуур Нийслэл хүрээнээс Харшаарын торгууд гүн Төмөржин, түүний дагалдах нэг хүн, Сайн ноён хан аймгийн Сайн ноён ханы хошууны мэйрэн Лхагва гэсэн гурван хүнд Ховдыг даруй орхиж зайлахыг амбанд шаардсан Засгийн газрын бичгийг авахуулан мордов. Тэд Улиастайгаар дайран өнгөрсөн тухай сайд Гончигдамба Дотоод яаманд бичиг илгээж ийн мэдээлжээ. Харшаарын торгууд гүн Төмөржин, түүний дагалдах нэг хүн, Сайн ноён хан аймгийн Сайн ноён ханы хошууны мэйрэн Лхагва гэсэн гурван хүн Дотоод яамнаас улаа шүүс хэрэглэх тамга дарсан бичигтэй, бас гүн Төмөржин Монголын улс төрд дагаар орсон тул, өргөмжилсөн тамгат бичгийг сайдад хамтаар үзүүлж миний бие одоо дөрвөдийн Далай хан, Чин ван нар лугаа уулзаар одмуй хэмээсэн тул зөвшөөрөл өгч цааш тэд ч замаа хөөсөн байна³⁰. Тэд Завханы адаг дахь А.В.Бурдуковын худалдааны суурингаас тэргэнд сууж Дамба худаг буюу

²⁶ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

²⁷ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-364, 11-р нугалбар

²⁸ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

²⁹ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

³⁰ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

Загийн тойруу хүрээд цааш Ховд хүртэл мянгадуудын хамт дан мориор явж Асановын пүүсэнд буужээ³¹.

Энэ дашрамд элч нарын үйл ажиллагааны талаар Бурдуковын өгүүлснийг сайд Гончигдамба, Ховдын халх жасааны мэдээгээр тодруулан авч үзье.

V.17-ны үес торгуудын гүн Төмөржин Сайн ноён хан аймгийн мэйрэн Лхагва, дагалдал нэг ийм гурван хүн Ховд дахь орос Мухулайн пүүсэнд ирээд дөрвөдийн Далай хан, Чин ван нар лугаа зөвлөн тогтсон хэмээн Ховдын манж нарыг үлдэн хөөхөөр амбанд шууд одсон байна³². Ингэхдээ гүн Төмөржин дагалдаа хүнээ уг пүүсэнд үлдээж³³, мэйрэн Лхагва болон Далай ханы хошууны нэгэн дөрвөд түшмэлийн хамт гурвуул Ховдын амбаны хэрэмд оржээ. Захиа бичгийг амбанд жич хүнээр хүргүүлж өөрөө Асановын пүүсэнд хүлээхийг оросын шилжин суугчид түүнд зөвлөсөн боловч тэрээр засгийн газрын даалгаврыг биечлэн биелүүлэх, тэгээд ч хятадууд түүнийг баривчлахгүй гэсэн итгэлтэй байв³⁴.

Гэвч хэрэг явдал өөрөөр эргэжээ. Манж сайд тэр гурвыг баривчилж, бүрэн төмөр торгож гянданд хорьж өдөр тутмын есөн туйпуу хэмжин дүүжилж чангалан шүүж эхэлжээ. Мөнөөх дагалдаа нь гарч чадахгүй Асаноовын пүүсэнд нуугдаж үлдэв³⁵. Хэд хоногийн дараа Далай ханы түшмэлийг суллаж тавьжээ³⁶.

Энэ бол тун санамсаргүй хэрэг байв. Тэднийг баривчилсан тухайд Бурдуков “олны ярих нь Төмөржин захиаг гардуулахдаа амбаны эсрэг сөргөлдсөн учир баривчлагдсан гэх ба хэрэг дээрээ арай ч тэгээгүй байх, харин амбан захиаг аваад Төмөржин гүнийг барьцаанд авсан болбуу” хэмээн таамаглажээ³⁷. Төмөржин гүнийг төд удалгүй итгэлийг тэрслэн цаазалснаас үзэхэд барьцаанд авсан явдал биш байлтай. Харин нутгийн ноёд санал хуваагдан зарим нь Богд хаанд дагаар орж байсан цаг үед манж сайд Монгол Улс, түүний төлөөний сайдаас огтхон ч эмээхгүй байгаагаа ил тод харуулж нутгийн монголчуудын өмнө сүрийг бадруулахыг эрмэлзсэн байсан байж болох юм. Түүнээс гадна Далай ханы түшмэлээс Төмөржин гүнд санаатайгаар буруу ташаа мэдээлэл өгснөөс үүдэн манж сайдтай тун эрээгүй харьцсан байж тун магад байна. Бидэнд буй мэдээгээр халх жасаанаас Асановын пүүсэнд хүн илгээж хэрхэн юуны учир баривчилсан талаар асуулгасанд Далай хан худлаар нийлж ийм болгосон хэмээн хариулсан тухай сайд Гончигдамбад илгээсэн бичигтээ халх жасаа дурдсан байна³⁸. Энэ нь Нийслэл хүрээний элч нарыг чангалан хорьж цаазлаад, харин тэдэнтэй хамтаар очсон Далай ханы түшмэдийг хэд хоногийн дараа буцаан суллан тавьснаас харагдаж байна.

Ийнхүү Монголчууд Ховдын асуудлыг энх тайвнаар шийдвэрлэх гэсэн сүүлчийн оролдлого элчээ цаазлуулснаар өндөрлөв³⁹.

Манж сайд хотыг хамгаалах хатуу байр суурьт зогсох болж, мөн Засгийн газрын оролдлого томоохон хохирол амсч, нэгэн эрэмгий зоримог монгол зүтгэлтнээ алджээ. Үүнтэй зэрэгцэн бас Ховдын халх жасаа үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болов. Ховдын манж сайд Төмөржин нарыг баривчлан эрүүдэж байхдаа Халх жасаа элдвийг уршигласан тул баривчлахаар хөдөлсөнд 1912.V.17-нд бие муутай Баатар, Түвдэн нар дутаан одож, Хар-Ус нуурын аралд бүглээ. Халх жасааны эрэлхэг хоёр түшмэл зам хуваан салах болов. Баатарын бие муу байсан тул Хар-Ус өртөөний газарт хоргодон үлдэж, өртөөний захирал тайж Жамсран лугаа нийлж, болсон хэрэг явдлыг сайд Гончигдамбад яаралтай мэдэгдэхээс гадна Засагт хан аймгийн

³¹ Бурдуков, А. В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 70-р тал

³² МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

³³ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

³⁴ Бурдуков, А. В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 70-р тал

³⁵ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

³⁶ Бурдуков, А. В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 70-р тал

³⁷ Бурдуков, А. В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 70-р тал

³⁸ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

³⁹ Бурдуков, А. В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 70-р тал

хамаарсан чуулганы дарга, дөрвөдийн зүүн гарын чуулганы дарга болон туслагч жанжин чин ван Содномжамц нарт нэн яаралтай мэдэгдэн бичээд, жасааны данс харааг уг өртөөнд тушааж харгалзууллаа. Түвдэн, Ховдын ойролцоо нууцаар очиж, хүн илгээж Ховдын байдлын тандах ба, орос пүүсэнд хоргодож байсан дагалдааг лам хувцас өмсгөн гаргаж авахыг хариуцжээ⁴⁰. Үүнээс хойш жасаатай харилцсан бичиг таарахгүй байгаа бөгөөд үүнээс үзэхэд Ховд хотын ойролцоо оршиж, Үндэсний хувьсгалын нууц штаб болж байсан Ховдын халх жасаа үүгээр бутарч, үйл ажиллагаагаа зогсоосон болов уу. Энэ дашрамд дурдахад, Ховдын халх жасааны энэ үеийн үйл ажиллагааг судлан тодруулах ажил эзнээ хүлээсээр буй билээ.

Монголчууд манж сайдыг шахамдуулан буцаах ямар ч найдлагагүй боллоо. Гагцхүү баруун хязгаарын олон монголчуудыг бүгдийг Монгол Улсад дагаар оруулж, хамтын цэргийн хүчээр Ховдыг байлдан эзлэх зам үлджээ. Нөхцөл байдал нэгэнт ингэж өөрчлөгдсөн тул хязгаарын хэргийг эрхэлсэн сайд Гончигдамба Богд хаанаас өөрт өгсөн эрхийн дагуу VI.5-нд Засагт хан, Сайн ноён хан аймгийн чуулган дарга, жанжин нарт хандан цэрэг дайчлах тушаал гаргасан байна⁴¹. Үүнд дараах арга хэмжээ авахыг заажээ. Нэгд, Засагт хан аймгаас нэг мянган цэрэг дайчлахаар зарлав. Цэргүүд цөм насан идэр, шилдэг эрс морь хэрэглэл, хүнс, зэвсгийн хамт байх ёстой байв. Хоёрт, Засагт хан аймгийн цэргүүдийн байрлалыг заав. Үүнд, Заяаханы аманд 100, Бумбатад 100, Харгана өртөөнд 300, Зогсоохайрханд 100, Цэнхэрбулагт 100, Ханхөхийн ар Адагбоомд 200 цэрэг тус тус суулган бэлтгүүлэхээр тушаасан байна. Гуравт, цэргүүд зургаа хоногийн дотор буюу 1912.VI.11 гэхэд заасан газарт бэлэн байхыг тушаав. Дөрөвт, цэргүүдийг ямар түшмэл даргалахыг томилж мэдэгдэхийг тушаав. Тавд, алгуурлаж заасан хугацаанаас хожимдвоос хатуу ял хэлэлцэхийг анхааруулав. Зургаад, Засагт хан аймгийн жанжин өөрийн биеэр яаралтай Улиастайд хүрэлцэн ирж хүчин хамжихыг даалгав. Долоод, эдгээрийг Сайн ноён хан аймгийн чуулган дарга, жанжин нарт мөн мэдэгдээд, нэг мянган цэргийг 1912.VI.11-нд Улиастайд бэлэн байлгахыг тушаав. Наймд, сайдын дэргэд туслагч жанжины тушаал буй тул түүнд Сайн ноён хан аймгийн харъяат ван, гүнгийн дотроос нэг хүнийг томилж мөн болзооноо Улиастайд ирүүлэхийг тушаав. Анх Гончигдамбыг томилсон тушаалд ийм туслах жанжинтай байх тухай үг үсэг үгүй агаад хожим нэмэн шийдвэрлэсэн асуудал бололтой. Үүнээс гадна тэрээр Дотоод яаманд хандан ийнхүү түгшүүртэй бүхийд баруун хоёр аймгийн хан нарын нэгийг томилон ирүүлбээс сахилга хүнд болох учрыг гуйжээ⁴². Монголчууд байлдах дайтахдаа туйлын хойрго, цэрэг цугларах нь удаан, зэвсэг муутай зэрэг учирт сайдын цэрэг дайчлах тушаал тун олон бэрхшээлтэй тулгарч, удаан хэрэгжиж болуужин хэмээн болгоомжилж ийнхүү аймгийн хантай хамтарч ажиллахыг эрмэлзжээ.

Зарлигаар зарсан Улиастай Ховдын хэргийг бүгд захиран шийтгэгч сайд чин ачит бэйс Гончигдамбад Богд хааны олгосон гурван сарын хугацаа нэгэнт дууссан боловч Ховдыг чөлөөлж баруун хязгаарын монголчуудыг бүрнээ дагуулан авсангүй, харин ч нөхцөл байдал эсрэгээр эргэж, хязгаар нутгийг Дундад Иргэн Улсад бүрнээ алдах аюул нөмрөх болов.

Энэхүү нөхцөл байдлыг дүгнэн үзээд, нөгөөтэйгүүр Дамдинсүрэн, Магсаржав нарыг Ховдод цэргийн ажиллагаа эхлүүлэхээр нэгэнт томилон илгээсэн тул 1912.VI сарын эхэнд Богд хаан Засгийн газарт хандан зарлиг гаргаж Гончигдамбыг халлаа⁴³. Үүнд, нэгд, Гончигдамбад олгосон хугацаа нэгэнт гүйцсэн ба, хязгаарын хэрэг тохинуулан чадаагүйн тулд халж Хүрээнээ ирүүлж уг алба болох Шүүх яамны дэд сайдын албыг хаалгах, хоёрт, Цэргийн яамны дэд сайд Наваанцэрэнг Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайдын тушаалд тохоон тавих, гуравт, шинэ сайд Наваанцэрэн Ховдын манж сайдыг хөөн зайлуулах хэрэгт торгууд, дөрвөд, захчин, өөлд, урианхай, мянгад лугаа нууц хэлэлцээр хийж санаа хүчийг нэгтгэх, дөрөвт, энэ хэргийг номун хан Жалханз хутагт Дамдинбазар лугаа зөвлөж шийдэхийг тус тус даалгажээ.

⁴⁰ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

⁴¹ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

⁴² МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 3-р нугалбар

⁴³ МУУТА, Ф-А3, Д-1, ХН-355, 1-р нугалбар

Үүгээр бэйс Гончигдамба Зарлигаар зарсан Улиастай Ховдын хэргийг бүгд захиран шийтгэгч сайдаар дөрвөн сар ажиллаад буцаж, харин түүний оронд цэргийн зүтгэлтнүүд Дамдинсүрэн, Магсаржав, Наваанцэрэн, шашин улс төргийн зүтгэлтэн Дамдинбазар нар Ховдыг чөлөөлөх хэргийг мэдэж гүйцэтгэхээр томилогдов.

Сайд чин ачит бэйс Гончигдамбын үйл ажиллагаа харилцан адилгүй үнэлэгдэж иржээ. Тухайлбал, Богд хаан түүнийг сайдаас халахдаа тогтоосон гурван сарын хугацаанд “хязгаарын хэрэг тохинуулан чадаагүй” гэж шүүмжилсэн байна⁴⁴. Тухайн үед баруун хязгаарт өрнөж байсан үйл явдлын гэрч, зарим үйл явдалд биечлэн оролцож байсныхаа хувиар Бурдуков түүнд тодорхой үнэлэлт өгсөн байна. Тэрээр “Го бэйс бол захирагчийн хувьд муу биш ч гэсэн цэргийн хүн биш болохоор командлагч болж ер чадахгүй нь илэрхий байлаа. Түүнийг командлагчаар томилсон явдал зөвхөн нэр төдий бөгөөд хэрэг дээрээ жинхэнэ командлагч нь Магсаржав байв” гэж дурсчээ⁴⁵. Бурдуков, Гончигдамбыг сайдаас буусныг мэдэлгүй захирагчийн хувиар ойлгож үнэлэлт дүгнэлт өгсөн бололтой байдаг. Ж.Урангуа, “Бэйсийн үйл ажиллагаа хангалтгүй байна хэмээн Монгол Улсын Засгийн газар үзсэн”⁴⁶ гэж бичээд, өөрөө тэр талаар тодорхой санал дэвшүүлээгүй байна.

Сайд Гончигдамба дараах үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

1. Ховдын манж сайдыг хөөн явуулах, баруун хязгаарын олон хошуудыг Богд хаанд дагаар оруулах үүргийг баруун хязгаарт ажиллаж байсан сайд нараас анх түрүүн төрийн сайдын ёсоор Гончигдамба хүлээж ажиллажээ.
2. Сайд Гончигдамба Улиастайд төвлөрч, Ховдын манж сайдад дипломат аргаар шахалт үзүүлэх, баруун хязгаарын Түгээмэл ван зэрэг зургаан ноёныг дагаар оруулах, Ховдын халх жасааг хүн хүчээр бэхжүүлж удирдах, баруун хоёр аймагт цэрэг дайчилгаа зарлаж цэрэг бүрдүүлэх, Улиастайн манж сайдын орхисон бичиг судрын зүйлсийг хадгалж хамгаалах, цэгцлэх зэрэг өөрөөс хамаарах бүхий л төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлж байв.
3. Түүний эрх хэмжээнд Сайн ноён хан, Засагт хан аймаг, баруун хязгаар, Улиастай, Ховд хотууд хамаарч, харъяалсан бүс нутагтаа цэрэг дайчлах онц эрхтэй байсан ба Хязгаарын түр захирагч гэж нэрийдэж болмоор байна.
4. Сайд Гончигдамбын үйл ажиллагааны үр дүнд Ховдын манж сайд удаа дараа буцахаар завдаж, мөн баруун хязгаараас анхны хошууд дагаар орж эхэлсэн байна. Мөн, түүний зарлан дайчилсан баруун хоёр аймгийн цэргүүд Дамдинсүрэн, Магсаржав нарын хүчийг ихээхэн зузаатгасан болно.
5. Түүний халагдсан шалтгаан бол Богд хаанаас олгосон гурван сарын хугацаанд Ховдыг чөлөөлж баруун хязгаарын хошуудыг дагуулан авч чадаагүй явдал юм. Гончигдамбын үйл ажиллагаа нэг талаас хангалтгүй, энгийн ард олонд хүрээгүй, шийдэмгий бус байсан нь үнэнтэй. Гэвч түүний хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үзэхэд сайд Гончигдамба Шинжаанаас тусламж авсан Ховдын манж сайд ба хэрхэхээ мэдэхгүй гайхан суух баруун хязгаарын хошуу ноёдын өмнө аргагүйдэж байсан нь харагдаж байна. Баруун хязгаарыг чухамхүү улс оронд нэр хүндтэй нэгдүгээр эгнээний улс төр, шашин, цэргийн зүтгэлтнүүд болоод нутгийн ноёд, халх, барга болоод нутгийн дөрвөд, урианхай зэрэг олон овгийн монгол цэргүүдийн хамтын тэмцлийн дүнд чөлөөлсөн билээ. Иймээс Гончигдамбыг 1912 оны II сард ганцааранг томилон гурван сарын хатуу хугацаа өгч хязгаар нутагт илгээсэн шийдвэр бол шинэ тутам байгуулагдсан Нийслэл хүрээний засгийн газраас Ховдын нөхцөл байдлыг хэтэрхий хялбарчлан үзэж, үүний улмаас бодлогын алдаа хийснийг харуулж байна.

⁴⁴ Ф-АЗ, Д-1, ХН-355, 1-р нугалбар

⁴⁵ Бурдуков, А, В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987, 72-р тал

⁴⁶ Урангуа, Хэрээд Ж, *XX зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919)*, УБ, 2006, 45-р тал

Эдгээрээс дүгнэн үзвэл,

1. Монголчууд Хүннү, Их Монгол Улсын үеэс хязгаар нутагт хааны төлөөний сайд томилогч суулгаж ирсэн уламжлалтай бөгөөд тэрхүү эртний нүүдэлчдийн төрт ёсны уламжлалыг Олноо өргөгдсөн Монгол Улс мөн адилхан залгамжлан авч, хязгаар нутагт төлөөний сайд суулгах болжээ. Төлөөний сайдын онцлог нь бусад аймгийн хан, ноёдоос онцлог, хүн амыг бус харин төрийн нутаг дэвсгэрийн тодорхой нэг хэсгийг мужлан захирагч байлаа.
2. Ховдыг чөлөөлөх түүхэн үйл хэргийн эхний үе буюу 1912 оны II-VI сард сайд Гончигдамба баруун хязгаарт голлох үүрэг гүйцэтгэж байжээ.
3. Чин ачит бэйс Гончигдамбын намтар судлалыг цаашид хөгжүүлж, түүний хязгаар нутагт сайдаар ажилласан үеийг хамруулан, бусад үеийг чухалчлан судлах нь зүйтэй юм.
4. Гончигдамба бол шинэ тулгар Монгол Улсаас баруун хязгаарт ажилласан анхны төлөөний сайд байв. Түүнээс хойш Дамдинсүрэн, Магсаржав, Наваанцэрэн, Хайсан, Цэрэнчимэд, Түмэндэлгэржав зэрэг арваад сайд ээлж дарааллан томилогдон ажилласан ба тэдний түүх бол баруун хязгаарын түүх болоод тухайн хувь хүмүүсийн намтар судлал болоод XX зууны монголын төрт ёсны түүхэнд нэн чухал холбогдох тул баруун хязгаарын тэдгээр олон сайдын ажил үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагааг цаашид тусгайлан судлах шаардлагатай билээ.

Abstract

In first half year of 1912, Gonchigdamba, Vice minister of Mongolian Justice affairs, had executed the role of Governor of Mongolian West Regions' Governor. He had conducted the affairs which are specifically, to avert the Manchu governor from Khovd, to unite West regions' some khoshuus to Bogd Khanate Monarchy, to mobilize armed forces from the West Region and to strengthen Khalkh office in Khovd, etc.

Эшлэл, зүүлт

1. Бурдуков, А, В, *Хуучин ба шинэ Монгол*, УБ, 1987
2. Нямдорж, Б, *Ховдын хязгаар 1911-1919 он*, УБ, 2006
3. Урангуа, Хэрээд Ж, *XX зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919)*, УБ, 2006
4. Бямбажаргал, Л, Цовоохүү, Ч, *Билиг аргын тоолол /XV, XVI, XVII жаран, 1867-2046/*, УБ, 2002
5. Чойбалсан, Х, *Ардын Хатанбаатар Магсаржав*, УБ, 1942
6. *Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал*, УБ, 2002
7. Болдбаатар, Ж, Лүндээжанцан, Д, *Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал*, УБ, 1997